

БАТЛАВ:

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ *М.Б.А.* Ш. БАЯНМӨНХ



БАТЛАВ:

“МӨНХ НАР ОД” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ *Ц.Мөнхбат* Ц. МӨНХБАТ



Нүүрс худалдах, худалдан авах гэрээ

2022 оны ⁰⁹ сарын ⁰⁸-ны өдөр

№ ⁹⁹/₂₀₂₂

Улаанбаатар хот

Энэхүү гэрээ нь нэг талаас “Амгалан Дулааны Станц”ТӨХК-ийг /Худалдан авагч/ гэх РД:6021646 төлөөлж **Ерөнхий инженер Э. Мөнхжаргал**, Нөгөө талаас “Мөнх нар од”ХХК РД:6106811 /Худалдагч гэх/- ийг төлөөлж **Захирал Ц. Мөнхбат** нар доорхи нөхцөлийг харилцан тохиролцож, Иргэний хуулийн 22-р бүлгийн 243-261-р зүйлийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний зорилго

1.1. Энэхүү гэрээгээр Худалдагч нь Худалдан авагч талд гэрээгээр тохиролцсон хуваарь, нөхцлийн дагуу нүүрс нийлүүлэх, Худалдан авагч нь гэрээгээр тохирсон хуваарь, нөхцлийн дагуу нүүрс хүлээн авах, Худалдагчид хүлээн авсан нүүрсний төлбөрийг төлөх нөхцөл болон эдгээр үйл ажиллагаатай холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Гэрээний зүйл, хугацаа

- 2.1. Худалдагчаас худалдан авагч талд нийлүүлэх **34.000** /Гучин дөрвөн мянган/ тонн чулуун нүүрс нь энэхүү гэрээний зүйл байна.
- 2.2. Худалдагч нь гэрээний зүйлийг 2022 оны 10-р сарын 01-ний өдрөөс 2023 оны 05-р сарын 15-ны өдрийн дотор 2.1. дэх хэсэгт заасан нөхцлөөр нийлүүлнэ.

Гурав. Нүүрсний чанар, үнэ, нүүрс нийлүүлэх нөхцөл

- 3.1. Нүүрсийг ФСА төмөр замын Олон Овоо өртөө /25-р зөрлөг/ дэх Худалдагчийн ачилтын талбайгаас захиалгат нүүрсийг Худалдан авагч талд нийлүүлнэ.
- 3.2. Гэрээний 3.1 дэх заасан нөхцлөөр нийлүүлэх 1тонн нүүрсний үнэ Олон-Овоот /25-р зөрлөг/ нөхцөлөөр 33000 төгрөг, /Гучин гурван мянга/ НӨАТ ороогүй байна.
- 3.3. Худалдан авагч нь тухайн үед Худалдагчаас ачуулж нүүрс нийлүүлсэний төлбөрийг нэхэмжлэлийн дагуу “Мөнх нар од”ХХК –ийн ХААН банкны 5021639480 тоот дансанд төлбөрийг шилжүүлэх ба төлбөр тооцоо бүрэн шилжиж ороогүй тохиолдолд дараа сарын 15-ны дотор үлдэгдэл төлбөрийг бүрэн хийнэ.
- 3.4. Гэрээний 3.3-д заасан хугацаанд төлбөр тооцоо бүрэн шилжиж ороогүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хоног тутам 0,1 хувийн алданги, харин сарын хуваарьт нүүрсийг Худалдан авагч талд нийлүүлж чадаагүй тохиолдолд нийлүүлээгүй нүүрсний үнийн дүнгээс хоног тутам 0,1 хувийн алданг тус тус тооцно.
- 3.5. Ачуулсан нүүрснийг Олон-Овоот өртөөн дэх УБТЗ-ын холбогдох анги, нэгжид хүлээлгэн өгснөөр бүтээгдэхүүн өмчлөх эрх нь Худалдан авагчид шилжих ба Олон-овоот өртөөн дэх

нүүрсний агуулахын салаа замаас Худалдан авагчийн хүлээн авах цэг хүртэл нүүрсний вагон тээвэрлэлтийн явц, нүүрсний хулгай, алдагдах эрсдлийг Худалдагч тал хариуцахгүй.

3.6. Нүүрс тээвэрлэгч нь Улаанбаатар төмөр зам /УБТЗ-ХНН/, түүний харьяа газар байна.

3.7 Худалдагч талын падаан бичигч нь төмөр замын Ачаа тээврийн үйлчилгээний цахим систем(АТҮЦС) программ ашиглан бичиг баримтуудыг цахимаар солилцож үнэн зөвөөр бичиж хугацаанд нь Хүлээн авагчид илгээнэ. Энэ нь тооцоо нийлэх үндсэн баримт болно.

Дөрөв. Худалдан авагчийн эрх, үүрэг

4.1. Гэрээний дагуу нийлүүлэгдсэн нүүрсийг төмөр замын “Амгалан Өртөө” салбарын “Амгалан Дулааны Станц”ТӨХК-ийн салаа зам дээр хүлээн авч, баримт бичиг бүрдүүлнэ. Худалдан авсан нүүрсийг дахин борлуулахтай холбогдон гарах аливаа зардал, татвар хураамжийг Худалдан авагч тал өөрөө хариуцна.

4.2. Худалдан авагч сар бүр хуваарийн дагуу нүүрс ачих вагоны захиалгыг төмөр замын холбогдох байгууллагад өгөх, тээврийн зардлыг төмөр замын байгууллагатай тохиролцон төлөх замаар Олон-овоот өртөөн дэх нүүрсний агуулахаас ачих боломжийг Худалдагч талд бүрдүүлж өгөх үүрэгтэй.

4.3. “Олон овоо” өртөөнөөс тээврийн явцад гарч болзошгүй аливаа эрсдэл, алдагдал болон тээвэрлэлтийн үйл явцтай холбоотой гомдол маргааныг Худалдагч тал хариуцахгүй бөгөөд Худалдан авагч тал тээвэрлэгч байгууллагатай бие даан шийдвэрлэнэ.

4.4. Гэрээний дагуу Худалдагч талаас нийлүүлсэн нүүрсийг цааш экспортонд гаргахгүй байх үүрэгтэй бөгөөд зөвхөн дотоодын хэрэгцээнд ашиглана. Хэрэв худалдан авагч тал экспортонд гаргасан тохиолдолд холбогдох аливаа татвар хураамж, хариуцлагыг Худалдан авагч тал бүрэн хариуцна. Үүнтэй холбоотой аливаа асуудал, татвар хураамж, хариуцлага нь Худалдагч талд хамаарахгүй болно.

4.5. Худалдагчаас гэрээ ба хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

4.6.Нүүрсний шавар, чулуулгын хольцын хэмжээ гэрээний 5.2 болон 5.7-д заалт зөрчигдвөл тусад нь ялгаж нүүрсний тооцоо хийхдээ нийлүүлсэн нүүрсний хэмжээнээс хасч тооцно.

4.7. Худалдагч талаас нийлүүлсэн нүүрсийг баталгаат вагон жингээр пүүлж хяналт тавьж нүүрс нийлүүлэлтэд зөрүү гарвал 2 талын Вагон жингийн дундаж хэмжилтээр тооцно.Хэрэв Худалдагч тал вагон жингүй бол Худалдан авагч талын Вагон жингээр тооцоо хийнэ.

4.8 Худалдагч талаас илгээсэн нүүрсэнд Худалдан авагч тал нүүрсний сорьц авч шинжилгээг хийлгэж баталгаажуулан сарын эцэст нүүрсний тооцоонд ашиглана.

4.9 Хоёр тал стандартын дагуу вагоны цуваа бүрээс сорьц авч өөрсдийн лабораториудад шинжлүүлж шинжилгээний дүнгийн дунджаар илчлэг, бусад үзүүлэлтийг тооцно. Лаборатори тус бүр сарын дундаж илчлэгээ арифметикийн дунджаар гаргана.Нүүрсний шинжилгээний дүнг тухайн бүрд нь цахимаар авч байна. Хэрэв Худалдагч талд нүүрсний лаборатори байхгүй бол Худалдан авагч талын лабораторийн шинжилгээгээр нүүрсний илчлэг тооцно.

4.10 Нүүрсний илчлэг 3250 ккал/кг-аас доош байвал нүүрсний илчлэгт үнийн зөрүү тооцно. 3350 ккал/кг-аас дээш бол илчлэгт үнийн зөрүү тооцохгүй.

4.11 3000 ккал/кг-аас доош илчлэгтэй, 100 мм фракцаас дээш ширхэглэгтэй, механик хольцтой, чийглэг 38%-аас дээш нүүрсийг хүлээж авахгүй, нүүрстэй вагоныг

Худалдагчийн талд буцаана. Энэ тохиолдолд хаяг солихтой холбогдон гарах тээврийн болон вагон таталт, тавилтын бүхий л зардлыг Худалдагч тал хариуцна.

Тав. Худалдагчийн эрх, үүрэг.

- 5.1. Худалдагч нь энэхүү гэрээний дагуу тохиролцсон хэмжээний нүүрсийг хуваарийн дагуу Худалдан авагчид бүрэн нийлүүлнэ.
- 5.2. Худалдагч нь /нунтаг 0-80мм-ээс ихгүй, дулаан гаргах чадвар 3000ккал/кг-аас багагүй, 4500 ккал/кг-аас ихгүй/ чулуун нүүрс нийлүүлж байх үүрэг хүлээнэ.
- 5.3. Худалдагч нь нийлүүлж буй нүүрсийг төмөр замын вагон жингээр вагон тус бүрээр пүүлж даацанд нь хүргэж ачих үүрэг хүлээнэ.Вагоны даацын тооцоог гэрээ дүгнэхдээ хийнэ.
- 5.4. Худалдан авагч тал нь гэрээнд заасан хугацаанд нүүрсний төлбөрийг Худалдагч талд төлөөгүйгээс хуваарьт хугацаанд гэрээнд заасан хэмжээний нүүрсийг хүлээн авч чадаагүй тохиолдолд Худалдагч тал нүүрс нийлүүлэхгүй байх эрхтэй ба үүнээс үүдэн гарах хариуцлагыг хүлээхгүй.
- 5.5. Төмөр замын байгууллагын дотоод үйл ажиллагаанаас хамааран вагон тавиагүй тохиолдолд үүнээс үүдэн гарах хариуцлагыг Худалдагч тал хариуцахгүй.
- 5.6. Худалдан авагч талаас энэхүү гэрээ ба хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
- 5.7. Нүүрсний ширхэглэлийн хэмжээ болон чанар зөрчигдөх, вагон ачилт дундуур, төмөр, механик хольц, шавар, чулуу, хайрга ачигдаж ирсэн тохиолдолд тэдгээрийн улмаас үүсэх хохирлыг талуудын төлөөлөгчид станц дээр очиж холбогдох хүмүүсийг байлцуулан акт тогтоож шийдвэрлэнэ.Шаардлагатай гэж үзвэл уул уурхайн хүрээлэнгийн нүүрсний хяналтын шинжилгээний лабораторийн шинжилгээг үндэслэн шийдвэр гаргана.
- 5.8. Худалдагч нь харьяа төмөр замын байгууллагад вагоны захиалгаа нэг хоногийн өмнө өгч нэг удаагийн ачилтаар 8 вагонаар ачилт хийх ба захиалгат вагонд УБТЗ-ын вагон үзэгч нартай хамтран үзлэг хийж гэмтэлтэй вагонд нүүрс ачихгүй байх.
- 5.9. Худалдагч талаас шалтгаалан нүүрсээ хуваарийн дагуу нийлүүлж чадаагүй тохиолдолд Худалдан авагчийн саналыг үндэслэн нийлүүлээгүй нүүрсийг дараа саруудад нөхөн нийлүүлж болно.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйл

- 6.1 Гал түймэр, үер ус, дайн байлдаан, мөргөлдөөн, цэргийн үйл ажиллагаа, засгийн газрын үйл ажиллагаа болон хориг, байгалийн онц аюултай үзэгдэл, ажил хаялт, бусад хөдөлмөрийн маргаан, бослого, үймээн самуун, жагсаал цуглаан, халдварт өвчин, дэлбэрэлт, хориг арга хэмжээ, үйлдвэрлэлийн осол, аваарь гэх мэт аль талыг хяналтаас гадуур нөхцөл байдлыг давагдашгүй хүчин зүйлд тооцно.
- 6.2. Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр уг гэрээ нь бүхэлдээ, эсвэл хэсэгчлэн биелэх боломжгүй болсон тохиолдолд тухайн тал энэхүү гэрээгээр биелүүлсэн үүрэг хариуцлага давагдашгүй хүчин зүйлийн хугацаатай тэнцүү хугацаагаар биелүүлэхээс чөлөөлөгдөнө.

Долоо. Гомдлын шаардлага ба чанарын асуудал

- 7.1. Ачих өртөөнд нүүрс ачигдах үед Худалдан авагч албан ёсны төлөөлөгчөө өөрийн зардлаар байлцуулан нүүрсний чанар болон жинлэлтэнд хяналт тавьж болно.
- 7.2. Ачих өртөөн дэх Худалдан авагчийн төлөөлөл нь нүүрсний чанарын үзүүлэлтийг гэрээнд заасан хэмжээнд хүрэхгүй байгааг нотолсон тохиолдолд вагон ачуулахгүй байх эрхтэй. Энэ тохиолдолд гөлөгдөл нүүрсний оронд ачилтын цэгээс өөр нүүрс ачиж өгөх үүрэг хүлээнэ.
- 7.3. Хөндлөнгийн лаборатори шаардлагатай бол МУ-ын уул уурхайн хүрээлэнгийн нүүрсний хяналтын шинжилгээний лаборатороор хийлгэх ба хариуг нь эцсийн гэж үзнэ.

Найм. Гэрээг цуцлах

8.1. Гэрээг хуульд зааснаас гадна дараах үндэслэлээр нэг талын санаачлагаар цуцлаж болно.

А. Аль нэг тал гэрээ ба хуулиар хүлээсэн үүргээ удаа дараа зөрчсөн ба үүнээс болж нөгөө тал нь хохирол хүлээсэн нь баримтаар нотлогдсон бол хохирол хүлээсэн талын санаачлагаар.

Б. Нүүрсний чанарын үзүүлэлт гэрээнд зааснаас доогуур байгааг Худалдагч тал хүлээн зөвшөөрсөн бол Худалдан авагчийн санаачлагаар.

В. Худалдагчийн нийлүүлэх нүүрсний нөөц дууссан буюу Худалдагч гэрээгээр хүлээсэн нүүрс нийлүүлэх үүргээ биелүүлэх боломжгүй болсон бол 7 хоногийн өмнө Худалдагч талд албан тоотой мэдэгдэж гэрээ цуцлах эрх үүснэ.

Ес. Гэрээний хугацаа

9.1. Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарснаас хойш 2023 оны 5-р сарын 15-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

9.2. Нүүрс нийлүүлсэн, худалдан авсан тооцоог 2 талын санхүүгийн ажилтан нар сар бүрийн ажлын эхний 3 хоногт тооцоо нийлж баталгаажуулна.

9.3. Гэрээг 2 тал харилцан тохиролцож гэрээ дүгнэсэн акт үйлдэнэ.

Арав. Бусад нөхцөл

10.1. Энэхүү гэрээг 2% үйлдэж тус бүр хадгална.

10.2. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагтай гэж үзвэл түүнийг хавсралтаар оруулна. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан хавсралт нь гэрээний салшгүй нэг хэсэг болно.


10.3. Хэрэглэгчдийн эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах зорилгоор төлөвлөгөөнөөс илүү үйлдвэрлэл явуулахад тэхнологийн хэрэгцээний нүүрс нэмж шаардагдвал энэхүү гэрээний хавсралтад нийлүүлэх нүүрсний хуваарьт албан тоотой хүсэлт тавьж өөрчлөлт оруулж болно.

10.4. Энэхүү гэрээтэй холбоотой маргаан гарвал талууд эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд ийнхүү шийдвэрлэх боломжгүй тохиолдолд МУ-ын иргэний хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Гэрээ байгуулсан:

Худалдан авагч талыг төлөөлж:

Ерөнхий инженер

 Э. Мөнхжаргал

СЭЗХ-ийн дарга

 О. Удвал

Ахлах инженер

 Б. Батцож

Зуухан цехийн дарга

 Э. Ариунболд

ТДЦ-ийн дарга

 Д. Түвшинзаяа

Хуулийн мэргэжилтэн

Г.Саруул

Хаяг: УБ хот БЗД, 8-р хороо,

УС-15-1-1 утас: 99662289, 99047300

Худалдагч талыг төлөөлж:

Захирал

 Ц. Мөнхбат

Нягтлан бодогч

 Д. Даваахүү



Хаяг: УБ хот БЗД, 26-р хороо,

Кристал таун-804, 709 тоот

Утас: 99115945, 99099417

2022-2023 онуудад “Мөнх нар од”ХХК -аас “Амгалан Дулааны Станц”-ТӨХК-д

нийлүүлэх нүүрсний хуваарь

МЯН. ТОНН

д/д	Үзүүлэлт	х/н	2022 он				2023 он					Нийт дүн	
			10	11	12	Бүгд	01	02	03	04	05		Бүгд
1	Нүүрс	тн	2.0	4.5	6.5	13.0	6.0	6.0	6.0	2.0	1.0	21.0	34.0

Хуваарь гаргасан:

“МӨНХ НАР ОД”ХХК -ийн

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ийн

Нягтлан бодогч

Ахлах инженер


 Д. Даваахүү


 Б. Батцоож